



"МЕРЕКС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03-р сарын 27-ний өдөр

№ 1 / 2023

Улаанбаатар хот

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
зардлын төсвийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалтыг үндэслэн, "Мерекс" ХК-ийн 2023 оны 03-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

- 1 Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг хавсралтаар нийт 23,600,000 (хорин гурван сая зургаан зуун мянга)-н төгрөгөөр БАТАЛСУГАЙ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БЯМБАБАЯР

"МЕРЕКС" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны зардлын төсөв / төгрөгөөр/

№	Зардлын нэр	Нхэгж зардал	Давтамж	Нийт дүн
1	ТУЗ-ийн даргын цалин	500,000	5	2,500,000
2	ТУЗ-ийн гишүүдийн цалин	420,000*8	5	16,800,000
3	ТУЗ-ийн НБД-ын цалин	500,000	5	2,500,000
4	ТУЗ-ийн хурлын зардал	200,000	4	800,000
5	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	1,000,000	1	1,000,000
Нийт дүн				23,600,000

Тайлбар:

"Мерекс" ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалинг биечлэн болон цахим байдлаар хуралд оролцсон бол олгох, хэрэв хуралд оролцоогүй бол цалин олгохгүй болно.



"МЕРЕКС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 03-р сарын 27-ний өдөр

№/ 2301

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон
хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай*

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэхь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Мерекс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 52,999,861 ширхэг хувьцааг эзэмшдэг 3 хувьцаа эзэмшигч саналаа өгсөн нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 81,5 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад МЭДҮҮЛСҮГЭЙ.
2. Компанийн хуулийн 69.1 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 81 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт ТООЦСУГАЙ.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн нийт 2 асуудлаар гаргасан шийдвэрийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн болохыг МЭДЭГДСҮГЭЙ.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА  Д.УЯНГА





"МЕРЕКС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 05-р сарын 27-ний өдөр

№ К/2302

Улаанбаатар хот

Саналын хуудас тооллогын үр дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, 72 дүгээр зүйл, санал хураалтын хуудсын тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
 - а. Зөвшөөрсөн 52,999,861 ширхэг хувьцаа буюу хуралд оролцогчдын 100 хувийн саналаар, татгалзсан, түдгэлзсэн санал өгөгдөөгүй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй байх ТУЗ-ийн шийдвэрийг батлах
 - а. Зөвшөөрсөн 52,999,861 ширхэг хувьцаа буюу хуралд оролцогчдын 100 хувийн саналаар, татгалзсан, түдгэлзсэн санал өгөгдөөгүй.
3. ТУЗ-ийн 2023 оны цалин урамшууллын төсвийг батлах
 - а. Зөвшөөрсөн 52,999,861 ширхэг хувьцаа буюу хуралд оролцогчдын 100 хувийн саналаар, татгалзсан, түдгэлзсэн санал өгөгдөөгүй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.УЯНГА



“МЕРЕКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03-р сарын 27-ний өдөр

№ Т/2604

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

“Мерекс” ХК-ийн 2023 оны 03-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанаар Компани нь хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэснийг БАТАЛСУГАЙ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БЯМБАБАЯР



"МЕРЕКС" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03-р сарын 27-ний өдөр

№ 17/2303

Улаанбаатар хот

*Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
ТУЗ-ийн дүгнэлтийн тухай*

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалтыг үндэслэн, Мерекс ХК-ийн 2023 оны 03-р сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БЯМБАБАЯР